

**“ТОСОНЦЭНГЭЛИЙН 4 ЗАМЫН УУЛЗВАР-НӨМРӨГ-СОНГИНО ЧИГЛЭЛИЙН 167 КМ
ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ ТӨСӨЛ”-ИЙН КОНЦЕССЫН ГЭРЭЭНД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2020 оны 3 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Энэхүү Гэрээ (цаашид “Нэмэлт гэрээ” гэх)-г Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, “Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн концессын гэрээний 6.2 дахь заалт, концесс эзэмшигчийн 2020 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 14 дугаар тоотой ирүүлсэн хүсэлтийг үндэслэн нэг талаас Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар /цаашид “Эрх бүхий этгээд” гэх/-ын дарга Б.Баярсайхан;

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Монгол ЛЗ зам гүүр” ХХК, түүнийг төлөөлж ерөнхий захирал Лю Шу Жүнь /цаашид “Концесс эзэмшигч” гэх/ нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

1.1. “Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км авто зам төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний 1.10 дахь заалтын “2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө” гэснийг “2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө” гэж өөрчлөн найруулав.

ХОЁР. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Энэхүү нэмэлт гэрээгээр нэмэлт өөрчлөлт оруулсан заалтуудаас бусад Концессын гэрээний зохицуулалт нь хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

2.2. Энэхүү нэмэлт гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд төслийн концессын гэрээний салшгүй хэсэг байна.

2.3. Нэмэлт гэрээ нь адил хүчинтэй 3 хувь үйлдэгдсэн бөгөөд Концессын гэрээний хугацаанд хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг:

Нэр: Б.Баярсайхан

Албан тушаал: Үндэсний хөгжлийн
газрын дарга

Тамга:



КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг:

Нэр: Лю Шу Жүнь

Албан тушаал: Ерөнхий захирал

Тамга:

